



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 1/58

Хархорин сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэмжилт зураглалын дрон нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: А.Норпил (Газрын даамал)

Гишүүд: Д.Бямба (Иргэний төлөөлөл)

Нарийн бичиг: Ж.Солонго (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, нийлүүлэгчийг сонгон шалгаруулж, дүгнэлт гарган танилцуулахыг Үнэлгээний хороо (А.Норпил)-д даалгасугай.

3.Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг (Ж.Солонго)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА:  Б.БАТ-ЭРДЭНЭ

